

ТАРИАЛАНГИЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон шаардлага, практик хэрэгцээ

1.1. Хуулийн төсөл боловсруулах болсон шаардлага

Монгол Улсад даатгалын үйл ажиллагааны нийтлэг харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Статистикийн тухай хууль, Тариалангийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоор зохицуулж ирсэн. Харин уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд тариалангийн салбарын байгаль, цаг уурын эрсдэлийн онцлогт нийцсэн индексэд суурилсан даатгалын харилцааг тусгайлан, иж бүрэн зохицуулсан бие даасан хууль өнөөдрийг хүртэл байхгүй байна.

Даатгалын тухай хуульд тариалангийн индексийн мэдээллийн эх сурвалж, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн хүснэгт, суурь зөрүү, даатгуулагчийн мэдээллийн хамгаалалт, гэрээний онцлог нөхцөл зэрэг индексжүүлсэн даатгалын нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна.

Үрийн тариалангийн даатгалын тухай хууль 1999 онд батлагдсан бөгөөд уг хууль нь зөвхөн үрийн тариаланг заавал даатгах болон зарим уламжлалт зохицуулалтыг агуулсан, бодит хохирол тогтоох зарчимд тулгуурласан байна. Тус хуулиар Монгол Улсад үрийн зориулалттай тариаланг тодорхой хувь, талбайн хэмжээнд албан журмаар даатгуулах харилцааны эрх зүйн үндсийг тогтоосон бөгөөд системийн шинжтэй их хэмжээний хохирол үүссэн тохиолдолд төрөөс нөхөн төлбөрийн зөрүүг хариуцах боломжийг хуульчилснаараа төрийн оролцоотой уламжлалт даатгалын загвартай бөгөөд үндсэндээ хэрэгжээгүй байна.

Газар тариалангийн үйлдвэрлэл нь хур тунадас, температур, хөрсний чийг, ган, хуурайшил, халууны давлагаа зэрэг уур амьсгалын хүчин зүйлээс ихээхэн хамааралтай, өндөр эрсдэлтэй салбар юм. Ийм эрсдэлийн үед бодит хохирлыг газар дээр нь тогтоож үнэлэх уламжлалт аргачлал нь цаг хугацаа, зардал их шаарддаг, маргаан дагуулдаг, ялангуяа жижиг, дунд хэмжээний тариалан эрхлэгчдэд хүртээмж багатай байдаг.

Индексжүүлсэн даатгал нь бодит хохирлыг газар дээр нь үнэлэхээс илүүтэйгээр тухайн даатгалын нэгжид тооцогдох индексийн үзүүлэлт урьдчилан тогтоосон босгыг хангасан эсэхэд үндэслэн нөхөн төлбөр олгодог онцлогтой. Иймд индексийн төрөл, мэдээллийн эх сурвалж, тооцох аргачлал, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн шаталсан болон хэсэгчлэн олгох загвар, суурь зөрүү, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоо, эрсдэлийн олон давхар

хуваарилалт, давхар даатгал, даатгуулагчийн эрхийн хамгаалалтыг бие даасан хуулиар нарийвчлан тогтоох шаардлага үүссэн.

1.2. Практик хэрэгцээ

Тариалангийн салбар нь Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нийлүүлэлт, хөдөө орон нутгийн орлого, ажлын байртай шууд холбоотой стратегийн ач холбогдолтой салбар мөн. Гэвч уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын хэлбэлзэл нэмэгдэж, ган, хуурайшил, хэт халалт, хөрсний чийгийн дутагдал зэрэг эрсдэл нэмэгдэхийн хэрээр ургацын хэлбэлзэл өсөж, тариаланчдын орлого тогтворгүй болох, санхүүгийн дарамт нэмэгдэх, зээл, хөрөнгө оруулалт татах чадвар сулрах сөрөг үр дагавар бий болж байна.

Индексжүүлсэн даатгал нь практикт дараах хэрэгцээг хангах боломжтой. Нэгдүгээрт, нөхөн төлбөрийг бодит хохирлын үнэлгээнд бус индексийн албан ёсны мэдээлэлд үндэслэн олгох тул шийдвэр гаргалт хурдан, зардал багатай, илүү ил тод байна. Хоёрдугаарт, индексийн мэдээллийг албан ёсны, тогтмол, шалгагдахуйц эх сурвалжаар тооцож нийтэд мэдээлэх боломжтой тул итгэлцэл нэмэгдэнэ. Гуравдугаарт, эрсдэлийг даатгуулагч, даатгагч, хамтын эрсдэлийн сан, давхар даатгал, шаардлагатай тохиолдолд төрийн дэмжлэгээр олон давхар хамгаалалтын хэлбэрээр хуваарилах нөхцөл бүрдэнэ. Дөрөвдүгээрт, суурь зөрүүний эрсдэл, нөхөн төлбөр олгогдох болон олгогдохгүй нөхцөл, даатгалын бүтээгдэхүүний үндсэн мэдээллийг даатгуулагчид урьдчилан ойлгомжтой хүргэх боломж бүрдэнэ.

Хуулийн төсөлд практик хэрэгцээг харгалзан индексийн мэдээллийн эх үүсвэрийг өргөжүүлж, цаг уурын албан ёсны мэдээлэл, даатгуулагчийн талбайд байршуулсан мэдрэгч төхөөрөмжийн мэдээлэл, ургацын статистик, зайнаас тандан судлал, хиймэл дагуулын өгөгдөл, баталгаажсан агро-мэдээллийн системийг ашиглах боломжийг тусгасан. Мөн даатгалын хамрах нэгжийг таримлын төрөл, газарзүйн байршил, даатгалын хугацаатай уялдуулан тогтоох, даатгуулах талбайг газар зүйн мэдээллийн системд бүртгэх, нэгжийн ангилал, индексийн тохирлыг тогтмол шинэчлэх, индексийн мэдээллийг хэмжилт-тайлагнал-баталгаажуулалтын тогтолцоонд тулгуурлан зохион байгуулах, богино хугацаанд бага талбайд нөлөөлөх зарим эрсдэлийг Даатгалын тухай хуулиар зохицуулах зэрэг нарийвчилсан зохицуулалтыг тусгасан нь хуулийн практик ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

1.3. Хууль зүйн үндэслэл

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төлөвлөгөөний 1.1.6-д “Тариалангийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3.1-д “Санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ”, 3.3.4.9-д “Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулна” гэж, мөн Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн 128-д “Тариалангийн даатгалын тухай” хууль батлахаар тус тус заасан байна.

Иймд тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бие даасан хуулиар тогтоох, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, даатгуулагч, даатгагч болон давхар даатгалын компанийн эрх, үүрэг, төрийн оролцоо, хяналт, хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг тодорхойлох хууль зүйн үндэслэл бүрдсэн байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго

Хуулийн төслийн зорилго нь тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, даатгуулагч болон даатгагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Тариалангийн индексжүүлсэн даатгалын нэр томьёо, зарчим, хамрах хүрээ, бүтээгдэхүүний хэлбэр, даатгалын нэгжийг хууль зүйн хувьд нэг мөр тодорхойлох;
2. Индексийн мэдээллийн эх үүсвэр, тооцох аргачлал, босго үзүүлэлт, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоог хуульчлах;
3. Нөхөн төлбөрийг индексийн өөрчлөлтийн түвшинтэй уялдуулан шаталсан, хэсэгчлэн байдлаар олгох эрх зүйн механизмыг тогтоох;
4. Даатгалын гэрээний зайлшгүй нөхцөл, суурь зөрүүний тайлбар, мэдээллийн үүрэг, даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулга зэрэг даатгуулагчийн эрхийн хамгаалалтын зохицуулалтыг бий болгох;
5. Эрсдэлийг доод, дунд, дээд түвшинд хуваарилж, хамтын эрсдэлийн сан, давхар даатгал, алдагдлаас хамгаалах сангаар зохицуулах;
6. Төрийн дэмжлэг, татаас, өгөгдөл, дэд бүтцийн дэмжлэг, туршилтын үе шаттай хэрэгжилтийг хуульчлах.

Гурав. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулиар тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдон үүсэх тусгай харилцааг зохицуулна. Даатгалтай холбоотой нийтлэг харилцааг Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулах бөгөөд индексжүүлсэн даатгалын онцлог зохицуулалтыг энэ хуулиар тусгайлан тогтооно.

Хуулийн төслийн хамрах хүрээнд тариалан эрхэлдэг иргэн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр даатгуулж болохоор тусгасан. Мөн даатгагч, давхар даатгалын компани, хамтын эрсдэлийн сан, статистик, цаг уур, газар тариалангийн мэдээллийн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагын хооронд үүсэх харилцаа хамрагдана.

Хуулийн төсөлд зохицуулалтын дараах агуулгыг хамруулна. Үүнд:

- индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг хур тунадас/ган, температур/халуун, хөрсний чийг, зайнаас тандах индекс, сумын дундаж болон тариалангийн талбайн ургацын индекс, олон индексийн хосолсон бүтээгдэхүүнээр ангилах;
- даатгалын хамрах нэгжийг таримлын төрөл, байршил, талбай, хугацаатай уялдуулан тогтоох;

- даатгуулагчийн талбайг газар зүйн мэдээллийн системд бүртгэх, нэгжийн бүртгэл, кодчилол, баталгаажуулалтын журмыг тогтоох;
- индексийн мэдээллийг нийтэд мэдээлэх, баталгаажуулах, алдаа засах, хөндлөнгийн баталгаажуулалт хийх тогтолцоог хуульчлах;
- даатгалын гэрээнд индексийн эх үүсвэр, нөхөн төлбөрийн хүснэгт, суурь зөрүүний тайлбар, мэдрэгч төхөөрөмж байршуулах нөхцөл, даатгалын хураамжийн хөнгөлөлтийн нөхцөлийг тусгах;
- даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулгыг даатгуулагчид заавал хүргүүлэх;
- эрсдэлийн дунд түвшний, дээд түвшний, алдагдлаас хамгаалах сан, хамтын эрсдэлийн сангийн тогтолцоог тодорхой болгох;
- төрийн татаас, өгөгдөл, дэд бүтцийн дэмжлэг, туршилтын хэрэгжилт, үе шаттай өргөтгөлийг зохицуулах;
- богино хугацаанд, бага талбайг хамарсан зарим эрсдэлийг индексжүүлсэн даатгалаас тусад нь Даатгалын тухай хуулиар зохицуулах.

Дөрөв. Хуулийн төслийн ерөнхий бүтэц

Хуулийн төсөл нь найман бүлэгтэй байна.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомжийн бүрэлдэхүүн, үйлчлэх хүрээ, үндсэн нэр томъёог тодорхойлно. Энэ бүлэгт “тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа”, “индекс”, “даатгалын нэгж”, “босго үзүүлэлт”, “суурь зөрүү”, “хэмжилт–тайлагнал–баталгаажуулалт”, “давхар даатгалын компани”, “эрсдэлийн дунд түвшний сан”, “эрсдэлийн дээд түвшний сан”, “алдагдлаас хамгаалах сан”, “хамтын эрсдэлийн сан” зэрэг үндсэн ойлголтыг хуульчилна.

Хоёрдугаар бүлэгт даатгалын үйл ажиллагаанд баримтлах зарчим, бүтээгдэхүүний хэлбэр, даатгалын нэгж, даатгалд хамруулах таримлын нэр төрөл, газарзүйн хамрах хүрээ, хугацаа, даатгалын хамрах нэгжийн бүртгэл, кодчилол, шинэчлэлтийн асуудлыг зохицуулна.

Гуравдугаар бүлэгт индексийн мэдээллийн эх үүсвэр, нийтэд мэдээлэх журам, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоо, индекс тооцох аргачлал, алдаа засах журам, босго үзүүлэлтийг тогтоох зарчим, эрсдэлийн түвшин, нөхөн төлбөрийн шаталсан болон хэсэгчлэн олгох механизмыг тодорхойлно.

Дөрөвдүгээр бүлэгт даатгалын хураамжийн актуар үндэслэл, даатгалын гэрээний зайлшгүй нөхцөл, суурь зөрүүний тайлбар, мэдээллийн үүрэг, нөхөн төлбөр олгох журам, даатгуулагчийн эрхийг хамгаалах, даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулга, санхүүгийн боловсрол олгох зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт эрсдэлийг доод, дунд, дээд түвшинд хуваарилах, хамтын эрсдэлийн сан, давхар даатгалын компани, олон улсын давхар даатгал, сангуудын зохион байгуулалт, төлөөлөн удирдах зөвлөл, нууцлал, мэдээллийн хамгаалалт, тайлан, аудит, нийтэд мэдээлэх асуудлыг зохицуулна.

Зургаадугаар бүлэгт төрийн дэмжлэг, татаас, өгөгдөл, дэд бүтцийн дэмжлэг, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоо бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Долоодугаар бүлэгт хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, гомдол, маргаан шийдвэрлэх, индексийн мэдээлэл, тооцооллын маргаанд хараат бус шинжээч, аудитын дүгнэлт ашиглах, хариуцлагын асуудлыг зохицуулна.

Наймдугаар бүлэгт шилжилтийн үе шатны зохицуулалт, туршилтын аймаг, суманд хэрэгжүүлэх, үе шаттай өргөтгөх, татаасыг аажмаар бууруулж зах зээлийн механизмд шилжүүлэх, туршилтын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, үр дүнгийн үнэлгээ, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Тав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

5.1. Нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар тариаланчдын байгаль, цаг уурын эрсдэлийг даван туулах боломж сайжирч, орлогын савлагаа буурах, үйлдвэрлэлийн тасралт багасах, хөрөнгө оруулалт болон санхүүжилт татах нөхцөл сайжрах эерэг үр дагавар гарна. Индексийн албан ёсны мэдээлэлд үндэслэн нөхөн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд олгох тул эрсдэлийн дараах санхүүгийн хоосон үе богиносож, дараагийн үйлдвэрлэлийн мөчлөгийг тасалдуулахгүй байх боломж нэмэгдэнэ.

Төрийн санхүүгийн хувьд гамшгийн дараах нэг удаагийн дэмжлэг, нөхөн олговрын арга хэмжээнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг зах зээл, даатгал, давхар даатгалын механизмаар хуваарилах зарчимд шилжих нөхцөл бүрдэнэ. Төрийн татаас, дэмжлэгийн хөшүүрэг тодорхой болж, аажмаар зах зээлийн механизмд шилжүүлэх зохицуулалт нь урт хугацаанд тогтвортой санхүүжилтийн схемийг бүрдүүлэх ач холбогдолтой.

5.2. Хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар индексжүүлсэн даатгалын нэр томьёо, бүтээгдэхүүн, гэрээ, босго үзүүлэлт, нөхөн төлбөрийн хүснэгт, мэдээллийн үүрэг, эрсдэлийн сан, хяналт, маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцаа илүү тодорхой болно. Даатгагч нь суурь зөрүү, нөхөн төлбөр олгогдох болон олгогдохгүй нөхцөл, индексийн тооцооллын үндэслэлийг даатгуулагчид урьдчилан тайлбарлах үүрэгтэй болсноор мэдээллийн тэгш бус байдал буурч, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт сайжирна.

Даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулгыг заавал хүргүүлэх, индексийн мэдээлэл, аргачлалыг нийтэд мэдээлэх, индексийн маргаанд хараат бус эксперт, аудитын дүгнэлт ашиглах, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоог хуульчлах нь маргаан багасах, хууль хэрэгжилтийн ил тод байдал нэмэгдэх, олон нийтийн итгэлцэл бэхжих эрх зүйн үр дагавартай.

Зургаа. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээтэй уялдах байдал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимтай нийцнэ. Тухайлбал, иргэн, хуулийн этгээдийн өмчлөх эрх, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх эрх, гэрээний эрх чөлөөг хүндэтгэхийн зэрэгцээ төрөөс хүнсний аюулгүй байдал, тогтвортой хөгжил, эрсдэлийн удирдлагыг дэмжих бодлоготой нийцэж байна.

Хуулийн төсөл нь Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Статистикийн тухай хууль,

Тариалангийн тухай хуультай харилцан нөхөх байдлаар хэрэгжинэ. Даатгалын ерөнхий харилцааг дээрх хуулиудаар зохицуулах бөгөөд тариалангийн индексжүүлсэн даатгалын онцлог зохицуулалтыг энэ хуулиар тусгайлан тогтооно.

Түүнчлэн давхар даатгалын компани, сангуудын зарим харилцаанд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг баримтлахаар тусгасан нь ижил төстэй индексжүүлсэн даатгалын туршлага, институцийн зохицуулалтыг ашиглаж буй хэлбэр юм.

Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөх зарчмыг тусгасан тул олон улсын үүрэг амлалттай нийцнэ.

Долоо. Хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн бусад зохицуулалт

Энэ хуультай уялдуулан Тариалангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд тус хуулийн 19 дүгээр зүйлд заасан мөнгөн урамшуулал, дэмжлэг үзүүлэх шалгуур үзүүлэлтэд тариалангаа индексжүүлсэн даатгалд хамруулсан байх нөхцөлийг тусгана.

Хуулийг хэрэгжүүлэхэд дараах журам, аргачлал, стандартыг боловсруулж батлах шаардлагатай:

1. Тариалангийн даатгалын нэгжийн бүртгэл, кодчилал, баталгаажуулалтын журам;
2. Тариалангийн индекс тооцох аргачлал, мэдээллийг баталгаажуулах, алдаа засах журам;
3. Хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх журам;
4. Даатгалын хураамж тогтоох, хэлэлцэх, баталгаажуулахтай холбоотой нарийвчилсан журам;
5. Гомдол, маргаан шийдвэрлэх шатлал, индексийн мэдээлэл, тооцооллын маргаанд хараат бус эксперт, аудитын дүгнэлт авах журам;

Эдгээр журмыг Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллагууд эрх хэмжээнийхээ хүрээнд батлахаар хуулийн төсөлд тусгасан.

Найм. Хуулийн төслийн хэрэгжилтийн үе шат, онцлог

Хуулийн төслийн хэрэгжилтийг шууд бүх нийтэд нэгэн зэрэг нэвтрүүлэх бус, эхний ээлжид туршилтын аймаг, суманд, өгөгдлийн бэлэн байдал хангагдсан таримал, индексийн төрлөөр хэрэгжүүлж, улмаар үе шаттай өргөжүүлэхээр тусгасан. Энэ нь индексийн мэдээллийн чанар, бүтээгдэхүүний үр нөлөө, хэрэглэгчийн ойлголт, санхүүгийн тогтвортой байдлыг бодит туршилтад үндэслэн үнэлэх боломж олгоно.

Туршилтын хэрэгжилтийн үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлж, түүний үндсэн дээр хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, татаасыг аажмаар бууруулж зах зээлийн механизмд шилжүүлэх боломжийг нээлттэй тусгасан.

Дүгнэлт

“Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай” хуулийн төсөл нь тариалангийн салбарын байгаль, цаг уурын эрсдэлийг илүү оновчтой, шинжлэх ухааны үндэслэлтэй, ил тод, зах зээлд нийцсэн аргаар удирдах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой анхдагч хуулийн төсөл юм. Хуулийн төсөлд индексийн төрөл, даатгалын нэгж, даатгалын гэрээний онцлог нөхцөл, хэмжилт–тайлагнал–баталгаажуулалт, нөхөн төлбөрийн хүснэгт, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт, эрсдэлийн олон давхар сан, төрийн дэмжлэг зэрэг зохицуулалтыг тодорхой тусгасан.

Иймд энэхүү үзэл баримтлал нь хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, бүтэц, хэрэгжилтийн үр дагавар, бусад хуультай уялдах байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн тодорхойлсон суурь баримт бичиг мөн.

---oOo---